Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.2 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 19.7 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.1 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.3 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд, 1.7 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 21. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас оны эхний 3 сард даатгуулагч, иргэдэд 184.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон байна.

Зураг 22. Даатгалын сангийн зарлага



Нийт зардлын 65.3 хувийг тэтгэврийн, 19.3 хувийг эрүүл мэндийн, 8.3 хувийг ҮОМШӨ-ний, 4.4 хувийг тэтгэмжийн, 2.7 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагч иргэдийн тоо 3-р сард 124.5 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 95.2 тэрбум төгрөгт хүрчээ.

Нийт олгосон тэтгэврийн 70.2 хувийг өндөр насны, 9.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.1 хувийг тэжээгчээ алдсаны, 13.0 хувийг цэргийн, 3.2 хувийг бусад тэтгэвэрт зарцуулсан байна.

### ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистикийн сарын мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл Улаанбаатар хотод энэ оны 3 дугаар сарын эцэст 12027 болж, өмнөх оны мөн үеэс 33.2 хувь буюу 5966 хүнээр буурчээ.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 19.1 хувь буюу 2293 нь Сонгинохайрхан, 16.7 хувь буюу 2012 нь Баянзүрх, 12.9 хувь буюу 1557 нь Сүхбаатар, 12.8 хувь буюу 1543 нь Налайх, 12.4 хувь буюу 1492 нь Чингэлтэй, 11.6 хувь буюу 1392 нь Баянгол, 10.0 хувь буюу 1207 нь Хан-Уул, 3.0 хувь буюу 357 нь Багануур, 1.5 хувь буюу 174 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Нийт ажилгүйчүүдийн 6174 буюу 51.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 18.4 хувь буюу 2210 нь 16-24 насны, 39.1 хувь буюу 4703 нь 25-34 насны, 24.0 хувь буюу 2893 нь 35-44 насны, 18.5 хувь буюу 2221 нь 45-59 насны хүмүүс байна.

Зураг 23. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



## Хүснэгт 18. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /4-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2011 он	2012 он	2013 он	2011 он	2012 он	2013 он
Нийт ажилгүйчүүд	9618	17993	12027	100	100	100
Үүнээс : Дээд боловсролтой	2545	7119	3967	26.5	39.6	33.0
Тусгай дунд боловсролтой	649	1160	954	6.7	6.5	7.9
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	528	1285	889	5.5	7.1	7.4
Ерөнхий боловсролтой	5852	8333	6155	60.8	46.3	51.2
Мэргэжилгүй	44	96	62	0.5	0.5	0.5

2013 оны 3-р сард ажилгүй 2531 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 2056 иргэн ажилд зуучлагдан орж, 1661 иргэн бүртгэлээс хасагджээ. 2013 оны эхний 3 сард 6676 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 20.0 хувь буюу 1113 хүнээр өсчээ. Энэ оны эхний 3 сард 3628 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 3.1 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 18.3 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 78.6 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

2013 оны эхний 3 сард 9265 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 872 хүүхдээр олон байна. Нийт төрсөн хүүхдийн 14.5 хувь буюу 1345 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна.

## Хүснэгт 19. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, оны эхний 3 сард

	2011 он	2012 он	2013 он	$\frac{2013}{2012}$ %	
Амаржсан эхийн тоо	7299	8348	9215	110.4	Нялхсын эндэгдлийн 23.1 хувь буюу 25 нь Сонгинохайрхан, 17.6 хувь буюу 19 нь Баянзүрх, 14.8 хувь буюу 16 нь Сүхбаатар, 13.9 хувь буюу 15 нь Баянгол, 13.9 хувь буюу 15 нь Хан-Уул, 9.3 хувь буюу 10 нь Чингэлтэй, 3.7 хувь буюу 4 нь Багануур,
Амьд төрсөн хүүхэд	7329	8393	9265	110.4	
Эхийн эндэгдэл	6	5	4	80.0	
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	114	104	139	133.7	
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	15.55	12.39	15.00	121.1	


3.7 хувь буюу 4 нь Налайх дүүрэгт тус тус гарсан байна. Нялхсын эндэгдлийн 22.3 хувь буюу 31 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 2.61 промилээр өсчээ.

Нийслэлд 2013 оны эхний 3 сард 4444 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 21.2 хувь буюу 1194 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 11.09 продицимилээр тус тус буурчээ.

Хүснэгт 20. Нийслэлд гарсан халдварт өвчин, оны эхний 3 сард

	Хэмжих нэгж	2012 он	2013 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	хувиар
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	5638	4444	- 1194	- 21.2
	10000 хүнд	47.61	36.52	- 11.09	
Вируст гепатит	бодит тоо	995	416	- 579	- 2.4 дах
	10000 хүнд	8.40	3.42	- 4.98	
Менингит	бодит тоо	5	10	5	2.0 дах
	10000 хүнд	0.04	0.08	0.04	
Цусан суулга	бодит тоо	220	186	- 34	- 15.5
	10000 хүнд	2.60	1.53	- 1.07	
Салхин цэцэг	бодит тоо	479	715	236	49.3
	10000 хүнд	4.04	5.88	1.84	
Гахай хавдар	бодит тоо	1492	569	- 923	- 2.6 дах
	10000 хүнд	12.59	4.68	- 7.91	
Сальмонеллэз	бодит тоо	6	4	- 2	- 33.3
	10000 хүнд	0.05	0.03	- 0.02	
Улаан эсэргэнэ	бодит тоо	26	50	24	1.9 дах
	10000 хүнд	0.22	0.41	0.19	
Хоолны хордлого	бодит тоо	19	18	- 1	- 5.3
	10000 хүнд	0.16	0.15	- 0.01	
Ёлом	бодит тоо	23	21	- 2	- 8.7
	10000 хүнд	0.16	0.17	0.01	
Улаанууд	бодит тоо	19	2	- 17	- 9.5 дах
	10000 хүнд	0.16	0.02	- 0.14	
Бруцеллэз	бодит тоо	10	2	- 8	- 5.0 дах
	10000 хүнд	0.08	0.02	- 0.06	
Гар хөл амны өвчин	бодит тоо	102	47	- 55	- 2.2 дах
	10000 хүнд	1.20	0.39	- 0.81	
Тэмбүү	бодит тоо	585	849	264	45.1
	10000 хүнд	4.94	6.98	2.04	
Заг хүйтэн	бодит тоо	475	424	- 51	- 10.7
	10000 хүнд	4.01	3.48	- 0.53	
Трихомониаз	бодит тоо	461	486	25	5.4
	10000 хүнд	3.89	3.99	0.1	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	580	571	- 9	- 1.6
	10000 хүнд	4.90	4.69	- 0.21	
ДОХ	бодит тоо	5	4	- 1	- 20.0
	10000 хүнд	0.04	0.03	- 0.01	

Зураг 24. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 19.1 хувийг тэмбүү, 16.1 хувийг салхинцэцэг, 12.8 хувийг сүрьеэ, 12.8 хувийг гахай хавдар, 10.9 хувийг трихомониаз, 9.5 хувийг заг хүйтэн, 9.4 хувийг вируст гепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

## ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2013 оны эхний 3 сард 736 гал түймэр гарсан нь өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар өсчээ. Төрийн өмчийн 176, хувийн өмчийн 514, аж ахуйн нэгж байгууллагын 45, хамтын болон гадаадын өмчийн 1 объектод гал түймэр гарч, 3.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Гал түймэрт 637 гэр орон сууц, 22 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 76 машин техник, 1 малын хашаа саравч их бага хэмжээгээр өртөж шатсан байна. Гал түймрийн улмаас 8 хүн (үүнээс хүүхэд 4) нас барж, 10 хүн түлэгдэж гэмтжээ.

Зураг 25. Гал түймэр, байршлаар



Гал түймрийн тохиолдлыг дүүргээр нь авч үзвэл 23.1 хувь буюу 170 нь Баянзүрх, 21.6 хувь буюу 159 нь Сонгинохайрхан 17.0 хувь буюу 125 нь Чингэлтэй, 14.7 хувь буюу 108 нь Баянгол, 12.2 хувь буюу 90 нь Сүхбаатар, 8.7 хувь буюу 64 нь Хан-Уул, 1.9 хувь буюу 14 нь Налайх, 0.8 хувь буюу 6 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна.

2013 оны эхний 3 сард 6918 өрх, 2744 объектод галын үзлэг шалгалт хийж, 17328 галын зөрчил илрүүлж гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, 331 хүн, 33 барилга байшин, 5.0 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг гал түймрийн аюулаас аварчээ.

2013 оны эхний 3 сард 3725 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14.9 хувь буюу 484 хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 48.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.1 пунктээр доогуур байна.

Зураг 26. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Гэмт хэргийн улмаас 1280 хүн гэмтэж осолдсоноос 13.7 хувь нь буюу 176 хүн нас барж, төр ард иргэдэд 27.9 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 20.7 хувь буюу 5.8 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2013 оны эхний 3 сард 16940 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 хувь буюу 331 хүнээр буурсан байна.

Хүснэгт 21. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, оны эхний 3 сард

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2012 он	2013 он	Тоо	Хувь
Хүний амь	39	35	- 4	- 10.3
Хүчин	37	44	7	18.9
Дээрэм	131	149	18	13.7
Хулгай	874	1119	245	28.0
Булаалт	33	51	18	54.5
Залилан	230	275	45	19.6
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	855	921	66	7.7
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	241	255	14	5.8
Бусдыг амиа хорлоход хүргэх	122	165	43	35.2
Ашиглах	34	50	16	47.1
Танхайрах	308	339	31	10.1
Бусад	337	322	- 15	- 4.5
<b>БҮГД</b>	<b>3241</b>	<b>3725</b>	<b>484</b>	<b>14.9</b>

Бүртгэгдсэн гэмт хэргийн 30.0 хувийг хулгайн, 24.7 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 9.1 хувийг танхайн, 7.4 хувийг залилан, 6.8 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг хэрэг, 4.4 хувийг бусдыг амиа хорлоход хүргэсэн хэрэг тус тус эзэлж байна.

## Хүснэгт 22. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, оны эхний 3 сард

Дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2012 он	2013 он	Тоо	хувь
Багануур	74	71	- 3	- 4.1
Багахангай	7	7	-	-
Баянгол	637	595	- 42	- 6.6
Баянзүрх	627	859	232	37.0
Налайх	70	81	11	15.7
Сонгинохайрхан	542	632	90	16.6
Сүхбаатар	569	644	75	13.2
Чингэлтэй	436	588	152	34.9
Хан-Уул	279	248	- 31	- 11.1
ДҮН	3241	3725	484	14.9

## Хүснэгт 23. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, 2013 оны эхний 3 сард

Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс: ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	17	12	70.6
Багахангай	1	-	0.0
Баянгол	199	115	57.8
Баянзүрх	460	185	40.2
Налайх	13	6	46.2
Сонгинохайрхан	347	205	59.1
Сүхбаатар	328	134	40.9
Чингэлтэй	295	142	48.1
Хан-Уул	102	55	53.9
ДҮН	1762	854	48.5


Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2755 болж, 2012 оны мөн үеэс 6.3 хувь буюу 163 хүнээр өссөн байна. Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 16.0 хувь буюу 440 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 25.9 хувь буюу 713 нь согтуугаар үйлдсэн, 5.0 хувь буюу 138 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 4.9 хувь буюу 134 нь хүүхэд, 16.7 хувь буюу 461 нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 24. Бүртгэгдсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, оны эхний 3 сард

Дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2012 он	2013 он	2012 он	2013 он
Багануур	7	17	2	13
Багахангай	2	-	2	-
Баянгол	179	144	156	116
Баянзүрх	185	290	160	232
Налайх	12	9	9	5
Сонгинохайрхан	167	226	148	191
Сүхбаатар	148	188	130	142
Чингэлтэй	96	175	78	149
Хан-Уул	78	70	73	66
ДҮН	874	1119	758	914

2013 оны эхний 3 сард хүндэвтэр хэрэг 1735, хөнгөн хэрэг 1593 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.2-23.7 хувиар өсч, онц хүнд хэрэг 86, хүнд хэрэг 311 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.4-5.8 хувиар буурчээ.

Зураг 27. Гэмт хэргийн тоо, ангиллаар






Нийтийн тээврээр зорчигчдын 46.1 хувь нь зорчих тасалбар худалдан авч, харин 53.9 хувь нь нөхөн олговроор үйлчлүүлжээ. Өөрөөр хэлбэл нийтийн тээврийн хэрэгслээр 2013 оны эхний 3 сард давхардсан тоогоор 37.1 сая зорчигч үнэ төлбөргүй үйлчлүүлж, төрөөс эдгээр хүмүүсийн үйлчилгээний 14.8 тэрбум төгрөгийн төлбөрийг нөхөн олговор хэлбэрээр аж ахуйн нэгжүүдэд шилжүүлсэн байна.

Хүснэгт 25. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, оны эхний 3 сард

Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж, тоо	Тээврийн хэрэгсэл, тоо	Орлого, тэрбум төгрөг	Үүнээс:		Зорчигч, сая хүн	Үүнээс:	
				зорчих тасал-бараар	нөхөн олгов-роор		зорчих тасал-бараар	нөхөн олгов-роор
Автобус (ТӨК)	2	252	8.0	4.0	4.0	22.6	12.6	10.0
Троллейбус (ТӨК)	1	44	0.6	0.4	0.2	2.2	1.2	1.0
Автобус (хувийн)	20	793	14.4	4.2	10.2	39.7	14.1	25.6
Троллейбус (хувийн)	1	15	0.2	0.06	0.14	0.6	0.19	0.41
Микроавтобус	35	1031	1.7	1.66	0.04	3.8	3.71	0.09
Дүн	59	2135	24.9	10.32	14.58	68.9	31.8	37.1

Нийслэлийн Тээврийн газраас аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ”-гээр насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусаар 400 төгрөг, троллейбусаар 200 төгрөг, туслах болон буухиа чиглэлийн бага оврын автобусаар 400-600 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2200 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Энэ гэрээнд таксины үйлчилгээний нэг төлбөрт километрийн тарифыг 600 төгрөгөөр тогтоож, үйлчилгээнд мөрдүүлэхээр заасан байна.

Зураг 31. Зорчигчдын тоо, сая хүн төлбөрийн хэлбэрээр



Зураг 32. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг, төлбөрийн хэлбэрээр



## Хүснэгт 26. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний тоо

Дансны хөдлөх бүрэлдэхүүн		2012.I-III	2013.I-III
Бүгд		2833	2870
Их, дунд багтаамжийн автобус	Төрийн өмч	251	252
	Хувийн өмч	771	793
Бага багтаамжийн автобус (хувийн)	Туслах чиглэл	456	476
	Бүүхиа чиглэл	570	555
Троллейбус	Төрийн	47	44
	Хувийн	-	15
Такси		738	735

Нийслэл хотод нийтийн зорчигч тээврийн зориулалтын 2870 хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлтэй байна.

Эдгээрийн 35.9 хувь нь бага багтаамжийн автобус, 36.4 хувь нь их, дунд багтаамжийн автобус, 25.6 хувь нь такси байна.

2013 оны эхний 3 сард нийтийн тээврийн парк шинэчлэлтээр их багтаамжийн 22 автобус, 64 такси үйлчилгээнд шинээр нэмэгдэж,

стандартын шаардлага хангахгүй болж 12-оос дээш жилээр ашиглагдаж хуучирсан 139 тээврийн хэрэгсэл (их, дунд багтаамжийн хувийн 7, төрийн өмчийн 1 автобус, бага багтаамжийн 48 автобус, 83 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.

2013 оны эхний 3 сард өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 797 автобус, 36 троллейбус, бага багтаамжийн 751 автобус, 588 такси, хот орчмын чиглэлд 80 тээврийн хэрэгсэл нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллажээ.

Улаанбаатар хотын замын хөдөлгөөний ачааллыг зохицуулах зорилгоор зарим замуудад тогтоосон хязгаарлалтын бүсэд хамаарах хэсгээр зорчих их багтаамжийн автобусны ашиглалтын хурд 15 км/цаг болоод байна.

## Зураг 33. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо



## Зураг 34. Хүлээлтийн хугацаа, минут




Нийтийн тээврийн үйлчилгээний “үндсэн чиглэл”-ийн хүлээлтийн хугацаа тогтмолжих хандлагатай байна. Зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу хүлээлтийн дундаж хугацааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага оврын автобусных 0.7 минутаар, их, дунд багтаамжийн автобусных 0.3 минутаар тус тус нэмэгдэж, цахилгаан тээврийн хүлээлтийн хугацаа 0.1 минутаар багасчээ.

2013 оны эхний 3 сард зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 1365 санал, гомдол Нийслэлийн Тээврийн газарт ирүүлсний 91.9 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна.

Зураг 35. Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх санал, гомдол, оны эхний 3 сард



Зураг 36. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлын шийдвэрлэлт, эхний 3 сард



**ХАРИЛЦАА ХОЛБОО****Хүснэгт 27. Холбооны салбарын үндсэн үзүүлэлт**

Шуудан, холбооны үйлчилгээний орлого 2013 оны эхний 3 сард 128.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.2 тэрбум төгрөгөөр буюу 6.0 хувиар өсчээ. Нийт орлогын 78.4 хувь буюу 100.3 тэрбум төгрөгийг нийслэлийн хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

Нийслэлд суурин телефон цэгийн тоо 2013 оны эхний 3 сард 115.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар нэмэгджээ.

	Хэмжих нэгж	2012.I-III	2013.I-III
Нийт орлого	сая төг	120714.7	128011.0
Үүнээс: хүн амаас	сая төг	93577.7	100359.0
Суурин телефон цэг	тоо	106021	115426
Үүнээс: айл өрхийн	тоо	70231	83493
Утасгүй телефон	тоо	29821	3578
Үүрэн телефон хэрэглэгч	мянган хүн	2117.5	1971.0
КаТВ-ийн хэрэглэгч	тоо	154027	217741

Нийт суурин телефон цэгийн 83.5 мянга буюу 72.3 хувийг айл өрх ашиглаж байна. Өрхийн суурин телефон цэгийн тоо 2012 оны мөн үеэс 18.9 хувиар өссөн нь гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгч өрхийн тоо нэмэгдсэнтэй холбоотой.

Зураг 37. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо




Зураг 38. Суурин телефон цэгийн тоо



2013 оны эхний 3 сард Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.5 сая гаруй хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 56.0 хувь буюу 1.9 сая гаруй хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчийн тоо нийслэлд 146.4 мянгаар буурсан нь үүрэн операторын компаниуд бүртгэлтэй нийт хэрэглэгчдээс идэвхтэй хэрэглэгчдийн дүн мэдээг нягталж тогтоосон явдалтай холбоотой.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 294.1 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1676.9 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 2012 оны мөн үеэс огцом буурсан нь Монголын Цахилгаан Холбоо ХК-ны F-zone үйлчилгээний хэрэглэгчдийг CDMA үйлчилгээнд шилжүүлэх зохицуулалтын арга хэмжээ авснаас шалтгаалжээ. Нийслэлд 0.9 мянга гаруй хэрэглэгч сансарын холбоог эзэмшиж байна.

Зураг 39. КаТВ, сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



Кабелийн телевизийн 19 аж ахуйн нэгж 2013 оны эхний 3 сард нийслэлийн 217.7 мянган хэрэглэгчдэд үйлчилжээ.

Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 95.6 хувь айл өрх байна.

Кабелийн телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 16 нь нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрлаж, хоногт дундажаар 50-110 хүртэл сувгаар, Налайх, Багануур дүүрэгт 3 аж ахуйн нэгж 34-50 сувгаар үйлчилжээ.

Кабелийн телевизийн сувагт холбогдох шинэ тавилтын үнэ нийслэлийн төвийн дүүргийн айл өрхөд 10.0-85.0 мянган төгрөгийн хооронд байхад үйлчилгээний төлбөрийн сарын хураамж өрхөд 3000-7000 төгрөгийн тарифтай байна.

### МАЛ ТӨЛЛӨЛТ, ТӨЛ БОЙЖИЛТ

2013 оны эхний 3 сард нийслэл хотын хэмжээнд нийт хээлтэгч малын 30.1 хувь буюу 44435 хээлтэгч төллөжээ. Нийт 44435 төл гарсны 879 төл мал хорогдож, 43556 төл бойжиж байна. Төл бойжилт 98.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр буурсан байна.

Хүснэгт 28. Төл бойжилт, дүүргээр, оны эхний 3 сард

Дүүрэг	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Төл бойжилт
Багануур	9907	9907	448	9459	95.5
Багахангай	484	484	2	482	99.6
Баянгол	2	2	-	2	100.0
Баянзүрх	10447	10447	325	10122	96.9
Налайх	1634	1634	-	1634	100.0
Сонгинохайрхан	18030	18030	69	17961	99.6
Сүхбаатар	425	425	5	420	98.8
Хан-Уул	3419	3419	30	3389	99.1
Чингэлтэй	87	87	-	87	100.0
Дүн	44435	44435	879	43556	98.0

Мал төллөлтийн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төллөсөн хээлтэгч 831 толгой буюу 1.9 хувиар, бойжсон төл 280 толгой буюу 0.6 хувиар, төл малын хорогдол 2.2 дахин өсчээ. Нийт бойжсон төлийн 0.02 хувийг ботго, 0.9 хувийг унага, 7.4 хувийг тугал, 46.5 хувийг хурга, 45.2 хувийг ишиг эзэлж байна.

## Хүснэгт 29. Төл бойжилт, төрлөөр, оны эхний 3 сард

	2012 он	2013 он	Үүнээс :				
			ботго	унага	тугал	хурга	ишиг
Гарсан төл	43670	44435	8	406	3307	20586	20128
Бойжсон төл	43276	43556	8	393	3210	20271	19674
Хорогдсон төл	394	879	-	13	97	315	454
Бойжилтын хувь	99.1	98.0	100.0	96.8	97.1	98.5	97.7

## Малын зүй бус хорогдол

## Зураг 40. Том малын зүй бус хорогдол, дүүргээр

2013 оны эхний 3 сард нийслэл хотод 1198 толгой том мал зүй бусаар хорогдсоны 23.1 хувь буюу 278 нь өвчнөөр хорогджээ.

Хорогдсон нийт малын 26.0 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Зүй бусаар хорогдсон малын 4.8 хувийг адуу, 13.5 хувийг үхэр, 40.5 хувийг хонь, 41.2 хувийг ямаа эзэлж байна.

Малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 1.8 дахин өсчээ.



## Хүснэгт 30. Том малын зүй бус хорогдол, дүүргээр, оны эхний 3 сард

Дүүрэг	2012 он	2013 он	Үүнээс :				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
Багануур	354	824	-	40	76	322	386
Багахангай	29	22	-	1	1	12	8
Баянзүрх	30	33	-	7	9	10	7
Налайх	64	35	-	-	14	11	10
Сонгинохайрхан	136	154	-	3	27	82	42
Сүхбаатар	7	8	-	-	3	1	4
Хан-Уул	26	120	-	6	30	47	37
Чингэлтэй	5	2	-	-	2	-	-
Дүн	651	1198	-	57	162	485	494

## АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн цаг агаар 2013 оны 3 сард дунджаар  $-6.3^{\circ}\text{C}$  байв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс  $1.7^{\circ}\text{C}$ -аар, олон жилийн дундажтай харьцуулахад  $1.4^{\circ}\text{C}$ -аар дулаан байлаа. Энэ сард хамгийн дулаан өдөр нь  $9.6^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн өдөр нь  $-20.8^{\circ}\text{C}$ , хур тунадасны нийлбэр 11.1 мм, салхины үнэмлэхүй их хурд 18 м/секунд хүрсэн.

Хүснэгт 31. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м<sup>3</sup>, 3 сард



	Стандарт хэмжээ	“Туул- Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		хэмжээ	бодисын хэтрэлт	хэмжээ	бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O <sub>2</sub> )	≥6	6.82	-	0.05	онцгой их бохирдсон
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ <sub>5</sub> )	≤ 3	1.70	-	488.0	162.7 дахин
Нитритийн нэгдэл (NO <sub>2</sub> )	≤ 0.02	0.001	-	-	-
Амоны азот (NH <sub>4</sub> )	≤0.5	0.040	-	37.77	76 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.002	-	1.600	16 дахин

Нийслэлд 2013 оны эхний 3 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 168 зөрчлийг илрүүлжээ. Зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 21.7 хувиар өссөн бөгөөд нийт зөрчлийн 49.4 хувийг ойн зөрчил, 28.0 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 11.9 хувийг газрын зөрчил, 7.7 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 3.0 хувийг бусад зөрчлүүд эзэлж байна. Илрүүлсэн зөрчилд 3.7 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.


Хүснэгт 32. Байгаль орчны зөрчил

Илрүүлсэн зөрчил төрлөөр	2012 оны эхний 3 сар			2013 оны эхний 3 сар		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/
Ой	12	36	3700.0	14	83	702.0
Ан, амьтан	-	-	-	1	1	280.8
Газрын	18	15	1844.4	20	20	1324.0
Ус	-	-	-	2	2	-
Ургамал, хөрсний бохирдол	72	61	1416.4	48	47	890.0
Агаар, химийн хорт бодисын	31	24	1042.4	15	13	187.0
Геодези зураг зүй, кадастр	2	1	-	1	1	-
Бусад	1	1	200.0	1	1	280.8
Бүгд	166	138	8203.2	102	168	3664.6

Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгт бохирдуулагч бодисын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн горим алдагдаж онцгой бохирдолтой, нитридийн нэгдэл /NO<sub>2</sub>/ хэмжилт хийгдээгүй, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ<sub>5</sub>/ 162.7 дахин, амоны азот /NH<sub>4</sub>/ 76 дахин, эрдэс фосфор /P/ 16 дахин хэтэрч, Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Зураг 41. Хүхэрлэг хийн агууламж, мг/м<sup>3</sup>Зураг 42. Азотын давхар ислийн агууламж, мг/м<sup>3</sup>Хүснэгт 33. Агаарын бохирдолт, мг/м<sup>3</sup>

Бодисын нэр	Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий /SO <sub>2</sub> /	0.020	143	0.091	79	0.027
Азотын давхар исэл /NO <sub>2</sub> /	0.040	139	0.232	95	0.039
Тоосжилт /PM <sub>10</sub> /	0.100	106	0.451	91	0.182
Тоосжилт /PM <sub>2.5</sub> /	0.050	28	0.221	17	0.068
Угаарын хий /CO <sub>2</sub> /	1.5	250	7.000	-	1.142
Озон /O <sub>3</sub> /	0.100	171	0.049	-	0.020

Зураг 43. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м<sup>3</sup>Зураг 44. Тоосны /PM<sub>10</sub>/ агууламж, мг/м<sup>3</sup>

Хүснэгт 34. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м<sup>3</sup>, 3-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл экспо	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруудын ордон	Хархорин зах
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	Дундаж	-	0.020	0.040	0.026	0.035	-	0.014
	Хамгийн их	-	0.039	0.091	0.048	0.069	-	0.022
	XXX*-с давсан хувь	-	54.8	80.0	56.7	80.6	-	12.9
	Хэмжилтийн тоо	-	31	20	30	31	-	31
Азотын давхар исэл NO <sub>2</sub>	Дундаж	-	0.210	0.029	0.066	0.041	-	0.036
	Хамгийн их	-	0.232	0.053	0.086	0.067	-	0.054
	XXX*-с давсан хувь	-	100.0	33.3	100.0	54.8	-	37.9
	Хэмжилтийн тоо	-	31	18	30	31	-	29
Нүүрстөрөгчийн дутуу исэл** CO <sub>2</sub>	Дундаж	-	1.689	-	1.075	-	-	0.663
	Хамгийн их	-	7.000	-	4.375	-	-	2.275
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	93	-	87	-	-	70
Тоос PM10	Дундаж	-	0.184	-	0.136	0.252	-	0.157
	Хамгийн их	-	0.346	-	0.226	0.451	-	0.298
	XXX*-с давсан хувь	-	93.5	-	66.7	100.0	-	88.0
	Хэмжилтийн тоо	-	31	-	30	20	-	25
Тоос PM2.5	Дундаж	-	0.068	-	-	-	-	-
	Хамгийн их	-	0.221	-	-	-	-	-
	XXX*-с давсан хувь	-	60.7	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	28	-	-	-	-	-
Озон O <sub>3</sub>	Дундаж	-	-	-	0.019	0.020	-	-
	Хамгийн их	-	-	-	0.049	0.048	-	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	78	93	-	-

\* - Хүлцэх хэм хэмжээ

\*\* - CO<sub>2</sub>, O<sub>3</sub> -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

## ХОТ ТОХИЖИЛТ

2013 оны эхний 3 сард нийслэлийн хэмжээнд тохижилтын ажил эхлээгүй тул зарим дүүрэг, хот тохижилтын компаниудын хийсэн урсгал ажлуудыг танилцуулж байна.

Хан-Уул дүүрэгт тохижилтын ажлаар 5 объект тохижуулснаас 1 объектыг нь иж бүрэн тохижуулж, 4 объектод бичил тохижилт хийж, 40.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Багануур, Хан-Уул дүүрэгт нийтийн эзэмшлийн зам талбайд 6 ширхэг сандал, 1 сүүдрэвч шинээр, 23 метр урт хайс хамгаалалтыг засварлаж, 5.2 км урт гэрэлтүүлэг хийсэн бөгөөд нийслэлийн хэмжээнд гэрэлтүүлгийн асалт дунджаар 90.7 хувь, хот нийтийн реклам асалт 89.3 хувьтай байлаа.

Энэ оны эхний 3 сард Налайх дүүрэгт тохижилтын ажлаар 27.7 мянган м<sup>2</sup> зүлэгжсэн талбай, 35.6 мянган цэцэрлэгжсэн талбай, 10742 ширхэг мод, 10000 ширхэг сөөгийг арчилж тордон 43.1 сая төгрөгийн ажил гүйцэтгэжээ.

Хүснэгт 35. Тээвэрлэсэн хог, мян.тонн, дүүргээр

Дүүрэг	Тээвэрлэсэн хог	Үүнээс: бүтцээр					
		Орон сууц	Гэр хороолол	Албан байгууллага	Зам талбай	Хур хог	Бохир шингэн
Багануур	17.6	3.8	9.1	2.8	1.8	0.1	-
Багахангай	5.6	1.0	4.0	-	0.6	-	-
Баянгол	16.4	6.8	5.0	3.5	1.1	-	-
Баянзүрх	53.5	13.4	34.6	3.5	1.3	0.7	-
Налайх	16.7	1.4	12.5	2.5	0.2	0.1	-
Сонгинохайрхан	18.5	2.8	13.9	1.4	0.4	-	-
Сүхбаатар	26.9	4.1	13.7	9.0	0.1	-	-
Хан-Уул	22.0	5.0	8.8	6.6	1.6	-	-
Чингэлтэй	9.4	2.3	2.8	1.6	1.7	1.0	-
Дүн	186.6	40.6	104.4	30.9	8.8	1.9	-

Хог цэвэрлэгээний ажлаар нийт 10853.5 мянган м<sup>2</sup> зам талбайг цэвэрлэж, 186.6 мянган тонн хог тээвэрлэж, 232.6 мянган тонн хогийг дарж устгасан байна. Дарж устгасан хогны 34.8 хувийг орон сууцны хорооллоос, 50.0 хувийг гэр хорооллоос, 12.7 хувийг аж ахуйн нэгж байгууллагаас, 2.5 хувийг зам талбайгаас гарсан хог эзэлж байна.

Хот тохижилтын газар 2013 оны эхний 3 сард 25720 золбин нохойг устгаж, уг ажилд 129.0 сая төгрөг зарцуулсан байна.

## НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2013 оны эхний 3 сард 8.4 сая м<sup>3</sup>, аж ахуйн нэгж, байгууллагад 2.8 сая м<sup>3</sup> цэвэр усыг борлуулжээ. Хүн амд түгээсэн цэвэр усны 96.2 хувь буюу 8.1 сая м<sup>3</sup>-ыг нь төвлөрсөн шугамаар, 314.3 мянган м<sup>3</sup>-ыг ус түгээх байраар, 2.4 мянган м<sup>3</sup> усыг тээврээр түгээсэн байна.

### Хүснэгт 36. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он III сар	2013 он III сар	$\frac{2013}{2012}$ %
Шахсан ус	мян.м <sup>3</sup>	13884.2	13997.1	100.8
Борлуулсан ус	мян.м <sup>3</sup>	10770.0	11142.0	103.5
Хүн амд	мян.м <sup>3</sup>	8267.5	8377.8	101.3
ААНБ-д	мян.м <sup>3</sup>	2502.5	2764.2	110.5
Татан зайлуулсан бохир	мян.м <sup>3</sup>	10536.4	11061.5	105.0
Хүн амаас	мян.м <sup>3</sup>	7780.5	7865.8	101.1
ААНБ-аас	мян.м <sup>3</sup>	2755.9	3195.7	116.0
Ус борлуулалтын орлого	сая төг	3648.4	3904.0	107.0
Хүн амаас	сая төг	2246.2	2351.4	104.7
ААНБ-аас	сая төг	1402.2	1552.6	110.7
Сувагжуулалтын орлого	сая төг	2044.7	2221.7	108.7
Хүн амаас	сая төг	1145.3	1158.2	101.1
ААНБ-аас	сая төг	899.4	1063.5	118.2

Цэвэрлэх байгууламжаар 14.0 сая м<sup>3</sup> бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 11.1 сая м<sup>3</sup> бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Энэ удаагийн дугаарыг Нийслэлийн Статистикийн газрын мэргэжилтэн Н.Байгалмаа эрхлэн гаргав.

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР